


БАТЛАВ.



2020 оны 02–р сарын 27.өдөр

НЭГ: НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Нэг талаас *Хөвсгөл аймгийн Засаг дарга* (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас *Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8 дугаар баг, “Хөвсгөл Дулаан Станц” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал* (цаашид “гүйцэтгэгч” гэх) нар дараах зүйлийг харилцан тохиролцож 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол улсын Монгол улсын Иргэний хууль, Эрчим хүчний тухай хууль, Орон сууцны тухай хууль, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, Засгийн газрын 2001 оны 263-р тогтоолоор баталсан “Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм”-д заасны дагуу дулааны эрчим хүч нийлүүлэх үйлчилгээтэй холбогдон захиалагч, гүйцэтгэгч, хэрэглэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь Хөвсгөл аймгийн төсөвт байгууллагуудад нэгдсэн халаалтаар дулааны эрчим нийлүүлэх *ХӨ-2020/8.8.01*-г (цаашид “ажил” гэх) 4 554 454 571,0 (дөрвөн тэрбум таван зуун тавин дөрвөн сая дөрвөн зуун тавин дөрвөн мянга таван зуун далан нэгэн) төгрөгөөр гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв.
3. Гэрээний нийт дүн: 4 554 454 571,0 (дөрвөн тэрбум таван зуун тавин дөрвөн сая дөрвөн зуун тавин дөрвөн мянга таван зуун далан нэгэн) төгрөг. Үүнээс : 2020 онд санхүүжих дүн 4 554 454 571,0 (дөрвөн тэрбум таван зуун тавин дөрвөн сая дөрвөн зуун тавин дөрвөн мянга таван зуун далан нэгэн) /Дулаан хэрэглэгч ААН байгууллагуудын талбайн хэмжээ, дулааны эрчим хүчний төлбөрийн дээд хязгаарыг хавсралтаар баталсан/ Урсгал төсвийн хөрөнгө оруулалтаар 4 554 454 571,0 (дөрвөн тэрбум таван зуун тавин дөрвөн сая дөрвөн зуун тавин дөрвөн мянга таван зуун далан нэгэн) төгрөг;
4. Гүйцэтгэгч нь Хөвсгөл аймгийн Мөрөн суманд үйл ажиллагаа явуулж буй төсөвт байгууллагуудад нэгдсэн халаалтаар дулааны эрчим хүч нийлүүлэх ажлыг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэнэ.

5. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний бичиг, баримт” гэх). Үүнд:

- Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- Гэрээний хавсралт, байгууллагуудын халаалтын эзэлхүүн, талбайн хэмжээ, тарифийн тооцоо



1.5. Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

1.6. Захиалагч, гүйцэтгэгч, хэрэглэгч талууд нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхдээ харилцан хүндэтгэлтэйгээр асуудалд хандаж, хэн нэг нь давуу эрх эдлэхгүйгээр хамтын шийдвэр гаргаж ажиллана.

1.7. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

1.8. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

1.9. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

1.10. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр харилцана.

1.11. Зайлшгүй шаардлагаар гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага гарвал талууд харилцан тохиролцож гэрээний үнэ, ажлын тоо хэмжээнээс бусад асуудлаар зохих өөрчлөлт оруулж болох бөгөөд тус өөрчлөлтийг бичгээр гаргаж талууд баталгаажуулсан нөхцөлд хүчин төгөлдөр болсонд тооцно.

ХОЁР: ЗАХИАЛАГЧ /АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ/-ИЙН ЭРХ, ҮҮРЭГ

2.1. Гэрээг баталгаажуулж байгууллагуудын харилцан хүлээсэн гэрээний үүргийн хэрэгжилтийг хянах, гэрээ зөрчигдсөн нь тогтоогдвол санхүүжилтийг зогсоох эрхтэй.

2.2. Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой байгууллагад өр төлбөр үүсч санхүүгийн хүндрэл үүсгэвэл захиалагчийн зүгээс “Цахилгаан, дулааны эрчим хүч, нүүрсний төлбөр тухай” хуулийн дагуу хэрэглэгч байгууллагын данснаас авлагатай орон нутгийн өмчит байгууллагад шууд шилжүүлэх эрхтэй.

2.3. Тогтсон хугацаанд байгууллагуудын дулааны эрчим хүч хэрэглэсэн төлбөр тооцоог өр төлбөр үүсгэхгүйгээр шилжүүлэх үүрэг хүлээнэ.

ГУРАВ: ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

Гүйцэтгэгчийн эрх

3.1 Компанийн зөвшөөрөлгүйгээр инженерийн шугам сүлжээнд дур мэдэн холболт хийсэн, усны тоолуурын өмнөх хэсгээс хэрэглэгч холбосон буюу тооцооны бүдүүвчийг өөрчилсөн, тогтоосон горимыг зөрчсөн, хангагч талын эрх бүхий

хүмүүсийн үйл ажиллагаанд саад учруулсан, тавьсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд хэрэглэгчийн дулааны эрчим хүч, хэрэгцээний халуун, хүйтэн ус, цахилгааныг Эрчим хүчний тухай хуулийн 32.2 заалтын дагуу хязгаарлана.

Гүйцэтгэгчийн үүрэг

3.2 Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээт тарифаар хэрэглэгч байгууллагуудтай гэрээ байгуулж дулааны эрчим хүчээр хэвийн найдвартай хангаж ажиллана.

3.3 Инженерийн шугам сүлжээнд хавар, намрын үзлэгийг тогтмол явуулж илэрсэн гэмтэл зөрчлийг арилгах, шаардлагатай арга хэмжээг авах ажил зохион байгуулах.

ДӨРӨВ. ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

Хэрэглэгчийн эрх

4.1 Дулааны эрчим хүч, хэрэгцээний халуун, хүйтэн усны хэрэглээгээ хязгаарлуулсан хэрэглэгч нь Түгээх төвийн зөвшөөрөлгүйгээр инженерийн шугам сүлжээнд дур мэдэн холболт хийхийг хориглоно

4.2 Хэрэглэгч нь хангагч байгууллагад хоногийн 24 цагийн турш дуудлага өгч засвар үйлчилгээг төлбөртэй хийлгэх эрхтэй.

4.3 Хэрэглэгч хянах хэмжих хэрэгсэл ээлжит баталгаажуулалт хийлгэх бол хангагчийн эрх бүхий ажилтныг байцуулан гүйцэтгэх бөгөөд уг ажиллагаанаас гарах зардлыг хэрэглэгч хариуцна.

4.4. Хангагч үүргээ зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд үйлчилгээний төлбөрийг бүрэн буюу зарим хэсгийг нь төлөхөөс татгалзах, хохирлоо нөхөн төлүүлэхээр хангагчаас нэхэмжлэх;

Хэрэглэгчийн үүрэг

4.5 Хэрэглэгч нь Монгол улсын Иргэний тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд заасан эрхийг эдэлж, үүрэг хүлээнэ.

4.6 Өөрийн эзэмшлийн инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хариуцаж, дулааны эрчим хүчний болон усны алдагдал гаргахгүй байх техник ашиглалтын болон аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдөж ажиллана.

4.7 Өөрийн эзэмшлийн инженерийн шугам сүлжээ, тоноглолд дулааны эрчим хүч, хэрэгцээний халуун, хүйтэн ус хангамжийн горимд нөлөөлөхүйц гэнэтийн гэмтэл гарвал хангагч байгууллагаар засварлуулах үүрэгтэй.

4.8 Дулааны эрчим хүч, Хэрэгцээний халуун, хүйтэн ус хангамжийн инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжинд зайлшгүй шаардагдах засварыг хангагч хийсэн бол төлбөрийг нэхэмжлэлийн дагуу төлөх үүрэгтэй.

4.9 Шугам сүлжээ, тоног төхөөрөмж зориулалтын дагуу хэвийн байдлаар ашиглахтай холбогдсон хангагчийн шаардлагыг биелүүлэх мөн шалан доор гэмтэл гарах, далд монтажлагдсан болон завсар дундын шугам хоолой цоорч гэмтэх үед далд шугамыг ил гарган Хэрэглэгчдэд үйлчилэх төвийн холбогдох хүмүүсийн ажиллах нөхцөлд саад учруулахгүй байх үүрэгтэй.

4.10 Хангагчаас тооцоолж битүүмжилж тавьсан дулаан тохируулах хэрэгсэл /сопло, шайба, балансын хаалт/-ийг дур мэдэн өөрчилсөн буюу зөвшөөрөлгүйгээр дулаан авч инженерийн шугам сүлжээнд холболт хийхийг хориглоно.

4.11 Хангагч байгууллагын хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах, шаардлагыг тогтоосон хугацаанд биелүүлэх үүрэгтэй.

ТАВ: ХАРИУЦЛАГА

5.1 Гүйцэтгэгч нь хэрэглэгчтэй энэ гэрээнд заасан тарифаар гэрээг нарийвчлан байгуулж гэрээний хариуцлагыг талууд бүрэн хариуцна.

5.2 Талууд бие биенийхээ өмнөөс гуравдагч этгээдийн өмнө ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.

5.3 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ бусдад шилжүүлэхгүй. Шилжүүлсэн тохиолдолд үүсэх үр дагаврыг шилжүүлсэн тал өөрөө хариуцна.

5.4 Хангагч хэрэглэгч байгууллагууд гэрээгээр хүлээсэн үүргээ чандлан биелүүлж ажиллах ба маргаантай асуудал гарч хоёр тал харилцан зөвшилцөлд хүрэхгүй бол хуулийн байгууллагаар шийдвэрлүүлнэ..

5.5 Энэхүү гэрээ нь хангагч, хэрэглэгч, ашиглагч байгууллагын дарга захирлуудын гарын үсэг, тамга тэмдэг дарж баталгаажсанаар хүчин төгөлдөр болж мөрдөгдөнө.

5.6 Энэхүү гэрээний сунгалтууд нь хоёр талын захирлуудын гарын үсэг, тамга тэмдэг дарснаар гэрээний адил хүчин төгөлдөр байна.

5.7 Гэрээний хэрэгжилттэй холбоотой маргаан гарсан тохиолдолд талууд харилцан зөвшилцөж шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд зөвшилцөж чадаагүй тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлнэ.

ЗУРГАА: ГЭРЭЭ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

6.1. Гэрээг 2 хувь үйлдэж захиалагч тал 1, гүйцэтгэгч тал 1 хувийг хадгална. Талууд гэрээнд гарын үсэг зурж тамга тэмдэг дарснаар гэрээ хүчин төгөлдөр болно.

6.2 Энэхүү гэрээний нөхцөлд гэрээний үнэ өөрчлөхөөс бусад асуудлаар нэмэлт гэрээ байгуулж болох бөгөөд уг нэмэлт гэрээ нь үндсэн гэрээний салшгүй хэсэг болно.

ДОЛОО: ГЭРЭЭ ДҮГНЭХ

7.1 Санхүүгийн жилийн эцэст талууд гэрээний хэрэгжилтийг дүгнэнэ

7.2 Захиалагчийн төслийн баг болон гүйцэтгэгч байгууллага хамтран ажил гүйцэтгэх гэрээг дүгнэнэ

**ЗАХИАЛАГЧИЙГ
ТӨЛӨӨЛЖ:**



ХЯНАСАН:

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ
ТӨЛӨӨЛЖ:**

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН
ӨМЧИЙН ГАЗРЫН
ДАРГА

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЗДТГ-ЫН ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

“ХӨВСГӨЛ ДУЛААНЫ
СТАНЦ” ТӨХК-ИЙН
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР


Б.БОЛД

Хөвсгөл аймаг, Мөрөн сум,
Аймгийн ЗДТГ-ын “А” байр
Утасны дугаар:
70382751, 70388849


Т.ГАНДЭЛГЭР



Ш.НЯМХАНД

Хаяг: Хөвсгөл аймаг, Мөрөн
сум, 8-р баг,
Утасны дугаар:

Хөвсгөл аймгийн Мөрөн суман дахь төсөвт байгууллага,
аж ахуйн нэгжид дулааны эрчим хүч нийлүүлэх
№ХӨА-2020/8.8.01 дугаар гэрээний хавсралт


ЗАХИАЛАГЧ:

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА
.....Л.ГАНБОЛД



Гэрээний хавсралт /Байгууллагуудтай байгуулах тариф, жилд төлбөл үнийн дүн/


№	Багцын нэр	Материалын нэр		Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнийн дүн	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа			
		Хэмжих нэгж	Тоо хэмжээ					ТШӨХ-Д заасан барааг агуулахад хүргэнэ	Бараа нийлүүлэх үлэх хамгийн эхний хугацаа а	Бараа нийлүүлэх эцсийн хугацаа	Бараа нийлүүлэх үеийн тэмдэг
1	Багц-1 нэгдсэн халаалта ар	Хө. Мөрөн. Гэгээрэл төв	М3	452.9	935	3,387,692.0	Төвлөрсөн халаалтын шугамаар дамжуулан байгуулагад хүргэнэ	2020 оны 01 сарын 01	2020 оны 09-р сарын 15-ны өдрөөс	2020 оны 12 сарын 12 сарын өдрөөс с.05-р	
2	Дулаан авдаг	Хө. Мөрөн. Сургууль /Дэлгэрмөрөн, цогцолбор/	М3	25,724.0	1716	353,139,072.0					
3		Хө. Мөрөн. Сургууль /2-р, ахлах/	М3	20,888.3	1716	286,755,131.5					

4	байгуул лагууд	Хе. Мөрөн. Сургууль /Эрдмийн далай, цогцолбор/	м3	27,100.3	1716	372,032,918.4	сарын 15 хүртэл	31 өдрийг дуустал	
5		Хе. Мөрөн. Сургууль /Гурван Эрдэнэ, ахлах/	м3	9,744.2	1716	133,768,377.6			
6		Хе. Мөрөн. Сургууль /Нутгийн аваргууд, спортын ахлах/	м3	9,552.0	1716	131,129,856.0			
7		Хе. Мөрөн. Сургууль /Авьяас, ахлах/	м3	5,722.0	1716	78,551,616.0			
8		Хе. Мөрөн. Цэцэрлэг /1-р/	м3	4,525.6	1716	62,127,436.8			
9		Хе. Мөрөн. Цэцэрлэг /2-р/	м3	4,090.9	1716	56,159,875.2			
10		Хе. Мөрөн. Цэцэрлэг /3-р/	м3	3,000.0	1716	41,184,000.0			
11		Хе. Мөрөн. Цэцэрлэг /4-р/	м3	2,216.0	1716	30,421,248.0			
12		Хе. Мөрөн. 15-р цэцэрлэг	м3	4,108.9	1716	38,779,703.8			
13		Хе. Мөрөн. Цэцэрлэг /6-р/	м3	3,495.2	1716	47,982,105.6			
14		Хе. Мөрөн. Цэцэрлэг /7-р/	м3	5,508.2	1716	75,616,706.9			
15		Хе. Мөрөн. Цэцэрлэг /8-р/	м3	1,056.7	1716	14,506,377.6			
16		Хе. Мөрөн. Цэцэрлэг /Бүрэнхаан/	м3	7,467.0	1716	102,506,976.0			
17		Хе. Мөрөн. Цэцэрлэг /10-р/	м3	2,713.0	1716	37,244,064.0			
18		Хе. Мөрөн. Цэцэрлэг /11-р/	м3	1,756.8	1716	24,117,350.4			

19	Хе. Мөрөн. Засаг даргын тамгын газар	м3	4,326.9	1716	59,399,683.2				
20	Хе. Мөрөн. Сургууль. /Сод-Эрдэм/	м3	16,783.2	1716	230,399,769.6				
21	Хе. Засаг даргын тамгын газар	м3	15,437.0	1,561.15	192,795,162.9				
22	Хе. Байгаль орчны газар	м3	2,166.0	1716	29,735,259.8				
23	Хе. Ахмад настны асрамж, тйлчилгээний газар	м3	1,328.0	1541.53	16,377,214.7				
24	Хе. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	м3	1,180.0	1716	16,199,040.0				
25	Хе. Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар	м3	10,429.1	1716	143,170,684.8				
26	Хе. Биеийн тамир спортын газар	м3	9,833.9	1716	134,999,779.2				
27	Хе. Соёлын төв /Хөгжимт драмын театр/	м3	12,189.8	1430	139,451,312.0				
28	Хе. Нийтийн номын сан	м3	2,746.0	1430	31,414,240.0				
29	Аймгийн нэгдсэн эмнэлэг	м3	57,202.7	1716	785,278,665.6				
30	Хе. Орон нутгийг судлах музей	м3	3,123.6	1430	35,733,984.0				
31	Зоонозын өвчин судлалын төв	м3	1,740.1	1716	23,888,092.8				



32	Эрүүл мэндийн газар	м3	4,737.7	1716	65,039,145.6			
33	МСҮТ	м3	13,694.5	1716	187,998,096.0			
34	Боловсрол соёлын газар	м3	2,462.4	1716	33,803,827.2			
35	Хөдөлмөр халамж үйлчилгээний газар	м3	827.7	1716	11,362,665.6			
36	Гаалийн хороо	м3	300.0	1716	4,118,400.0			
37	МХГазрын лаборатори	м3	988.7	1716	13,572,873.6	Инкотерми йн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
38	Мэргэжлийн хяналтын газар	м3	4,421.7	1716	60,700,960.3			
39	Эрүүл мэнд нийгмийн даатгалын хэлтэс	м3	1,383.0	1716	18,985,824.0			
40	Татварын хэлтэс	м3	1,282.0	1716	17,599,296.0			
41	стандарт хэмжилзүйн хэлтэс	м3	529.6	1716	7,270,348.8			
42	Улсын бүртгэлийн хэлтэс	м3	2,632.0	1716	36,132,096.0			
43	Цагдаагийн газар	м3	4,541.6	1716	62,347,084.8			
44	тагнуулын алба	м3	808.7	1716	11,101,833.6			
45	Прокурор	м3	742.3	1716	10,190,294.4			
46	Хүнс хөдөө аж ахуйн газар	м3	758.5	1716	10,412,688.0			
47	мал эмнэлэгийн газар	м3	1,346.3	1716	18,482,006.4			



48	Шүүх тамгын газар	МЗ	2,582.6	1716	35,453,932.8				
49	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	МЗ	3,518.6	1716	48,303,340.8				
	онцгой байдлын газар	МЗ	2,036.3	1716	27,953,914.6				
	Зэвсэгт хүчнийн 321-р анги	МЗ	847.3	1716	11,631,048.0				
51	Хилийн цэргийн 0257-р анги	МЗ	4,693.5	1716	64,432,368.0				
52	Хөвсгөл Эрчим Хүч ХХК	МЗ	5,851.3	935	43,767,350.0				
53	Хөвсгөл Эрчим Хүч ХХК	МЗ	1,489.6	935	11,142,208.0				
54	Хөвсгөл Эрчим Хүч ХХК	МЗ	1,489.6	935	11,142,208.0				
	Хөвсгөл Эрчим Хүч ХХК	МЗ	1,489.6	935	11,142,208.0				
55	Хөвсгөл Эрчим Хүч ХХК	МЗ	1,489.6	935	11,142,208.0				
	Хөвсгөл Эрчим Хүч ХХК	МЗ	1,489.6	935	11,142,208.0				
56	Хөвсгөл Эрчим Хүч ХХК	МЗ	1,489.6	935	11,142,208.0				
	Хөвсгөл Эрчим Хүч ХХК	МЗ	1,489.6	935	11,142,208.0				
1 дүгээр багцын дүн			342,389.4	90,508.7	4,554,454,571.0				



 ӨМӨЗО-ны
 Хөгжлийн үйлчилгээний
 газар
 ӨМӨЗО-ны
 Хөгжлийн үйлчилгээний
 газар

ӨТ: 6718120351

№: 4131053